



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН САЛБАР

Арилжаа эрхлэгчдийн тоо

39

Хуулийн этгээд



Салбарын төлөв

425

Иргэн

Худалдаж, худалдан
авсан үнэт металл

868.5

тэрбум төгрөг



Бүтээгдэхүүн, үйлчилгээ

Хүртээмжтэй байдал



82.2%

Улаанбаатар хотод үйл
ажиллагаа эрхэлж байна

Бодлого зохицуулалт



САЛБАРЫН ТӨЛӨВ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН ТОО:

СЗХ 2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрөөс үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож эхэлснээр 2021 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 39 хуулийн этгээд, 425 иргэн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг эрхэлж байна.

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД

39



65

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧ

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ АРИЛЖАА
ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ
ИРГЭД

125



235

ҮНЭТ МЕТАЛЛ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГААР
ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ
ИРГЭД

ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ

Тайлант хугацаанд 61 хувьцаа эзэмшигчдийн 8.5 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй 39 хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.

Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй нийт тусгай зөвшөөрөлтэй арилжаа эрхлэгчдийн 82.2 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 17.8 хувь нь хөдөө, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна.

Улаанбаатар хотод

82.2%

БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ


ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ МЕТАЛЛЫН ДҮН

2021 оны 3 дугаар улирлын байдлаар 464.3 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдаж, 404.2 тэрбум төгрөгийн үнэт металлыг худалдан авчээ.

ҮНЭТ МЕТАЛЛ ЭРХЛЭГЧИД БОЛОН ИРГЭД, АЖ АХУЙ НЭГЖ ХООРОНДЫН АРИЛЖАА



ХУДАЛДАЖ, ХУДАЛДАН АВСАН ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ДҮН



БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ



ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааны 2021 оны хагас жилийн тайлангийн нэгтгэлийг бэлтгэж, 2021 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр СЗХ-ны цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн.
- СЗХ-ны 2020 оны 182 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалтын журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулсан төслийг 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Санхүүгийн зохицуулах хорооны цахим хуудсанд байршуулж, олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулсан.
- СЗХ-ны даргын 2021 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 213 дугаар тушаалын дагуу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагааны стратеги бодлого, хууль тогтоомж, журам, дагаж мөрдөх шалгуур үзүүлэлт, стандартыг боловсронгуй болгох судалгаа шинжилгээ хийх, нэгдсэн мэдээллийн санг бий болгох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулах олон улсын зөвлөхийг сонгон шалгаруулсан. Зөвлөх үйлчилгээний хүрээнд нэр бүхий 5 улсын хууль, эрхзүйн зохицуулалтын талаар харьцуулсан судалгааг гаргасан.



ХУРАЛ, СЕМИНАР, УУЛЗАЛТ

- СЗХ болон салбарын мэргэжлийн холбооны төлөөллийг оролцуулан үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулахаар сонгон шалгарсан олон улсын зөвлөхтэй цахим уулзалтууд зохион байгуулсан.
- СЗХ-ноос Үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхлэгчдийн дэвэр нэгдсэн холбоо, Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоотой хамтран “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа-2021” форумыг зохион байгуулсан.

